



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2026/410/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 327734 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Отгонбаяр  
Утас: 325093 Цахим хаяг: [otgonbayard@audit.gov.mn](mailto:otgonbayard@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мэдээлэл аудит ХХК-ийн  
захирал: Д.Товуудорж  
Утас: 99049511 Цахим хаяг: [medeelelaudit@gmail.com](mailto:medeelelaudit@gmail.com)

Улаанбаатар хот  
2026 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-02-25 № 146  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН  
ДАРГА П. ДАВААСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Дэлхийн улс орнуудын музейн үзвэр үйлчилгээ цаг үеэ даган уламжлалт хэв маягаас дижитал, цахим хэлбэрт шилжиж байгаатай зэрэгцэн тус музей дижитал технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна.

Мөн үзүүлэгийн танхим дахь шилэн хоргонууд нь 2004-2008 онд хийгдсэн, хуучирч муудсан, стандартын шаардлага хангахгүй болсон тул шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 98.4 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>54,809,886.62</b>	<b>51,647,398.00</b>
33	АВЛАГА	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54,809,886.62	51,647,398.00
354	Хангамжийн материал	54,809,886.62	51,647,398.00
35410	Бичиг хэргийн материал	1,185,180.00	1,200,480.00
35420	Аж ахуйн материал	2,139,000.00	1,753,500.00
35470	Бусад хангамжийн материал	51,485,706.62	48,693,418.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>744,890,896.27</b>	<b>813,816,278.72</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	744,890,896.27	813,816,278.72
392	Биет хөрөнгө	698,878,596.27	758,157,464.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	101,445,362.80	177,768,370.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(65,724,808.60)	(74,192,739.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,720,000.00	43,720,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(43,720,000.00)	(43,720,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	175,403,712.83	196,356,212.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	(70,153,494.59)	(100,774,061.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,044,441.99	43,544,441.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,028,245.20)	(17,436,387.00)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	527,229,319.04	528,229,319.04
39217	Ном	4,662,308.00	4,662,308.00
393	Биет бус хөрөнгө	46,012,300.00	55,658,814.00
39301	Програм хангамж	2,378,400.00	12,288,914.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,212,400.00)	(1,476,400.00)
39305	Газар эзэмших эрх	44,846,300.00	44,846,300.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>799,700,782.89</b>	<b>865,463,676.72</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,360,470.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,360,470.00
413	Өглөг	-	1,360,470.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		635,470.00
4136	Бусад өглөг		725,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		725,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>799,700,782.89</b>	<b>864,103,206.72</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	799,700,782.89	864,103,206.72
511	Засгийн газрын оруулсан капитал	99,872,456.01	99,872,456.01
512	Хуримтлагдсан үр дүн	221,801,126.24	286,203,550.07
51210	Өмнөх үеийн үр дүн	107,314,509.06	221,801,126.24
51220	Тайлант үеийн үр дүн	114,486,617.18	64,402,423.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	478,027,200.64	478,027,200.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>799,700,782.89</b>	<b>865,463,676.72</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>807,005,429.14</b>	<b>958,098,599.36</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>104,720,242.67</b>	<b>82,603,558.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	104,720,242.67	82,603,558.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,612,500.00	3,311,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,612,500.00	3,227,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		84,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	99,415,406.67	79,292,558.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	692,336.00	0.00
122	Тусламжийн орлого	0.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод/		
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>702,285,186.47</b>	<b>875,495,041.36</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,980,000.00</b>	<b>96,602,200.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,980,000.00	96,602,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	693,305,186.47	778,892,841.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	693,305,186.47	778,892,841.36
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>692,518,811.96</b>	<b>893,696,175.53</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>692,518,811.96</b>	<b>893,696,175.53</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>658,230,695.96</b>	<b>865,727,787.53</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>502,688,411.27</b>	<b>614,047,821.54</b>
210101	Үндсэн цалин	281,091,051.75	319,056,667.59
210102	Нэмэгдэл	96,163,672.80	111,172,638.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,027,000.00	132,566,000.00
210104	Урамшуулал	39,406,686.72	51,252,515.29
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх</b>	<b>63,813,231.58</b>	<b>77,170,384.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,133,205.24	54,403,080.50
210202	Тэтгэмжийн даатгал	5,309,788.87	6,400,362.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,522,894.43	3,063,561.26
210204	Ажилгүйдлийн даатгал	2,167,488.62	2,660,676.15
210205	Эрүүл мэндийн даатгал	8,679,854.42	10,642,704.37
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,153,677.45</b>	<b>9,541,540.04</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,058,659.25	4,591,636.66
210302	Түлш, халаалт	3,623,849.20	3,788,352.59
210303	Цэвэр, бохир ус	1,471,169.00	1,161,550.79
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,404,987.41</b>	<b>12,818,637.00</b>
210401	Бичиг хэрэг	1,938,240.00	1,838,350.00
210402	Тээвэр, шатахуун	1,182,228.00	1,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,221,216.17	4,382,930.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,407,500.00	1,440,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,377,396.00	3,697,507.00

**Улаанбаатар хотын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	90,200.00	
210408	Бараа материал акталсаны зардал	14,188,207.24	9,350.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>400,000.00</b>	<b>0.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,083,300.00</b>	<b>10,914,678.62</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		462,200.00
210604	Урсгал засвар	11,083,300.00	10,452,478.62
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,745,320.00</b>	<b>11,818,460.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,688,060.00	6,091,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,600,000.00	2,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	218,010.00	106,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,200.00	246,160.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,140,200.00	1,636,900.00
210807	Газрын төлбөр	290,640.00	290,640.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	739,210.00	846,440.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,941,768.25</b>	<b>129,416,265.55</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,295,766.00	76,015,226.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,100,660.00	10,640,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,545,342.25	42,760,639.55
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,288,116.00</b>	<b>27,968,388.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,455,616.00	24,657,388.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	28,435,616.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		21,607,388.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,020,000.00	3,050,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>832,500.00</b>	<b>3,311,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	832,500.00	3,311,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>114,486,617.18</b>	<b>64,402,423.83</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>114,486,617.18</b>	<b>64,402,423.83</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>706,897,686.47</b>	<b>878,806,041.36</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,612,500.00</b>	<b>3,311,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,612,500.00</b>	<b>3,311,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,612,500.00	3,311,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,612,500.00	3,227,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		84,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>702,285,186.47</b>	<b>875,495,041.36</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,980,000.00</b>	<b>96,602,200.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,980,000.00	96,602,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	693,305,186.47	778,892,841.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	693,305,186.47	778,892,841.36
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>686,675,186.47</b>	<b>846,412,577.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>686,675,186.47</b>	<b>846,412,577.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>652,387,070.47</b>	<b>818,444,189.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>502,688,411.27</b>	<b>613,412,351.54</b>
210101	Үндсэн цалин	281,091,051.75	319,056,667.59
210102	Нэмэгдэл	96,163,672.80	110,537,168.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,027,000.00	132,566,000.00
210104	Урамшуулал	39,406,686.72	51,252,515.29
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>63,813,231.58</b>	<b>77,170,384.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,133,205.24	54,403,080.50
210202	Тэтгэмжийн даатгал	5,309,788.87	6,400,362.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,522,894.43	3,063,561.26
210204	Ажилгүйдлийн даатгал	2,167,488.62	2,660,676.15
210205	Эрүүл мэндийн даатгал	8,679,854.42	10,642,704.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,153,677.45</b>	<b>9,541,540.04</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,058,659.25	4,591,636.66
210302	Түлш, шатахуун	3,623,849.20	3,788,352.59
210303	Цэвэр, бохир ус	1,471,169.00	1,161,550.79
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,289,896.17</b>	<b>11,529,087.00</b>
210401	Бичиг хэрэг	1,375,540.00	1,451,150.00
210402	Тээвэр, шатахуун	1,145,000.00	1,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,221,216.17	4,382,930.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,407,500.00	1,440,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,140,640.00	2,804,507.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>400,000.00</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,083,300.00</b>	<b>4,835,100.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		462,200.00
210604	Урсгал засвар	11,083,300.00	4,372,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,101,550.00</b>	<b>12,390,120.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,259,300.00	4,629,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,600,000.00	2,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	218,010.00	106,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,200.00	246,160.00

**Улаанбаатар хотын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,165,000.00	1,636,900.00
210807	Газрын төлбөр	290,640.00	290,640.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,499,400.00	2,880,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,857,004.00</b>	<b>89,565,606.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,912,904.00	85,614,826.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,944,100.00	3,950,780.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>33,455,616.00</b>	<b>24,657,388.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	28,435,616.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		21,607,388.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,020,000.00	3,050,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>832,500.00</b>	<b>3,311,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	832,500.00	3,311,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>20,222,500.00</b>	<b>32,393,464.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,222,500.00</b>	<b>32,393,464.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,222,500.00	32,393,464.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-20,222,500.00</b>	<b>-32,393,464.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>99,872,456.01</b>	<b>478,027,200.64</b>	<b>107,314,509.06</b>	<b>685,214,165.71</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн			114,486,617.18	114,486,617.18
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>99,872,456.01</b>	<b>478,027,200.64</b>	<b>221,801,126.24</b>	<b>799,700,782.89</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн			64,402,423.83	64,402,423.83
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>99,872,456.01</b>	<b>478,027,200.64</b>	<b>286,203,550.07</b>	<b>864,103,206.72</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>891,809,400.00</b>	<b>778,892,841.36</b>	<b>112,916,558.64</b>	<b>87.3%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>891,809,400.00</b>	<b>778,892,841.36</b>	<b>112,916,558.64</b>	<b>87.3%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>865,751,800.00</b>	<b>754,235,453.36</b>	<b>111,516,346.64</b>	<b>87.1%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>661,972,700.00</b>	<b>613,412,351.54</b>	<b>48,560,348.46</b>	<b>92.7%</b>
Үндсэн цалин	301,171,400.00	319,056,667.59	(17,885,267.59)	105.9%
Нэмэгдэл	149,676,100.00	110,537,168.66	39,138,931.34	73.9%
Унаа хоолны хөнгөлөлт	160,930,000.00	132,566,000.00	28,364,000.00	82.4%
Урамшуулал	50,195,200.00	51,252,515.29	(1,057,315.29)	102.1%
<b>Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>82,746,700.00</b>	<b>77,170,384.78</b>	<b>5,576,315.22</b>	<b>93.3%</b>
Тэтгэврийн даатгал	56,267,700.00	54,403,080.50	1,864,619.50	96.7%
Тэтгэмжийн даатгал	6,619,700.00	6,400,362.50	219,337.50	96.7%
ҮОМШӨ-ний даатгал	3,309,900.00	3,063,561.26	246,338.74	92.6%
Ажилгүйдлийн даатгал	3,309,900.00	2,660,676.15	649,223.85	80.4%
Эрүүл мэндийн даатгал	13,239,500.00	10,642,704.37	2,596,795.63	80.4%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,456,400.00</b>	<b>9,541,540.04</b>	<b>9,914,859.96</b>	<b>49.0%</b>
Гэрэл, цахилгаан	6,845,700.00	4,591,636.66	2,254,063.34	67.1%
Түлш, халаалт	9,733,100.00	3,788,352.59	5,944,747.41	38.9%
Цэвэр, бохир ус	2,877,600.00	1,161,550.79	1,716,049.21	40.4%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,555,800.00</b>	<b>11,529,087.00</b>	<b>1,026,713.00</b>	<b>91.8%</b>
Бичиг хэрэг	1,488,000.00	1,451,150.00	36,850.00	97.5%
Тээвэр, шатахуун	2,237,800.00	1,450,000.00	787,800.00	64.8%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,464,000.00	4,382,930.00	81,070.00	98.2%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,470,000.00	1,440,500.00	29,500.00	98.0%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,896,000.00	2,804,507.00	91,493.00	96.8%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,475,000.00</b>	<b>18,818,050.00</b>	<b>656,950.00</b>	<b>96.6%</b>
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	462,200.00	637,800.00	42.0%
Урсгал засвар	18,375,000.00	18,355,850.00	19,150.00	99.9%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тхур</b>	<b>48,164,200.00</b>	<b>15,890,120.00</b>	<b>32,274,080.00</b>	<b>33.0%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,999,000.00	8,129,500.00	31,869,500.00	20.3%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	2,600,000.00	2,600,000.00	0.00	100.0%
Даатгалын үйлчилгээ	270,000.00	106,920.00	163,080.00	39.6%
Тээврийн хэрэгслийн татвар	246,200.00	246,160.00	40.00	100.0%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00		20,000.00	0.0%
Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,729,000.00	1,636,900.00	92,100.00	94.7%

**Улаанбаатар хотын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Газрын төлбөр	300,000.00	290,640.00	9,360.00	96.9%
Улсын мэдээллийнн маягт хэвлэх, бэлтгэх	3,000,000.00	2,880,000.00	120,000.00	96.0%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,381,000.00</b>	<b>7,873,920.00</b>	<b>13,507,080.00</b>	<b>36.8%</b>
Бараа үйлчилгээний бусал зардал	6,420,000.00	3,923,140.00	2,496,860.00	61.1%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,961,000.00	3,950,780.00	11,010,220.00	26.4%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,057,600.00</b>	<b>24,657,388.00</b>	<b>1,400,212.00</b>	<b>94.6%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,057,600.00</b>	<b>24,657,388.00</b>	<b>1,400,212.00</b>	<b>94.6%</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,607,600.00	21,607,388.00	212.00	100.0%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,450,000.00	3,050,000.00	1,400,000.00	68.5%
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>891,809,400.00</b>	<b>782,203,841.36</b>	<b>109,605,558.64</b>	<b>87.7%</b>
Орон нутгийн төсвөөс санхүүжих	888,029,400.00	778,892,841.36	109,136,558.64	87.7%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,780,000.00</b>	<b>3,311,000.00</b>	<b>469,000.00</b>	<b>87.6%</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,780,000.00	3,227,000.00	553,000.00	85.4%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		84,000.00	(84,000.00)	0.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>19</b>	<b>19</b>		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	13	13		
Үйлчлэх ажилтан	5	5		

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	96,602,200.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	96,602,200.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	96,602,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	96,602,200.00
210801	Бараа үйлчилгээний бусад зардал	96,602,200.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	96,602,200.00
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	96,602,200.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	96,602,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доош шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	96,602,200.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанбаатар хотын музей нь Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлийн хайгуул судалгааг хийж, сан хөмрөгийг баяжуулах, музей судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулах, музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзмэрийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохиомжтойгоор дэглэн нийтийн хүртээл болгох үүрэгтэй байгууллага юм.

Улаанбаатар хотын музейн нь эрхэм зорилгоо 'нийслэл хотын хөгжлийн түүх, соёлын өвийг баримтжуулан хадгалж, хамгаалах, хойч үедээ уламжлуулах, иргэдийн оюуны эрэлт хэрэгцээг хангах, тэдний боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх' гэж тодорхойлсон байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон, 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдөнө.
- Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээ

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналт аас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллага нь дотоод хяналтын хэлтэс, дотоод аудиторгүйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар хотын музейн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Улаанбаатар хотын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Улаанбаатар хотын музейн байгууллагын удирдлагын 2017 оны А/07 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Улаанбаатар хотын музейн 2025 оны санхүүгийн тайланг сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,762.89 мянган төгрөгөөр буюу 8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	54,809.9	51,647.4	(3,162.5)
Үндсэн хөрөнгө	744,890.9	813,816.3	68,925.4
Нийт хөрөнгө	799,700.8	865,463.7	65,762.9
Өр төлбөр	-	1,360.5	1,360.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	799,700.8	864,103.2	64,402.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	799,700.8	865,463.7	65,762.9

Бараа материал нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 60,755.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 63,908.7 мянган төгрөгөөр хасагдаж, 51,647.4 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь өмнөх оны үлдэгдэлээс 5,7 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө 68,925.3 мянган төгрөгөөр өссөн. Үүнд: 3,500.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдаж авсан, нийтийн эзэмшлийн бетондсон зам талбай, явган замын засварын ажил хийлгүүлсэн 13,982.9 мянган төгрөг, 5,000.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 9,910.5 мянган төгрөгийн програм хангамж зэрэг нийт 32,393.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдаж авсан. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 1/633 дугаар албан бичиг, Захирлын 2025 оны А/17 дугаар тушаалаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн барилгын урсгал засварын ажлын гүйцэтгэлийн дүн 62,340.0 мянган төгрөгөөр музейн барилгыг капиталжуулсан. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 1/1928 дугаар албан бичиг, Захирлын 2025 оны А/33 дугаар тушаалаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн 15,952.5 мянган төгрөгийн үнэ бүхий Dell 24 маркын 3 ширхэг суурин компьютер, 1ш олон үйлдэлт принтерийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн. Захирлын 2025 оны А/23 дугаар тушаалаар музейн сан хөмрөгт нэр бүхий 4 иргэнээс 1,000.0 мянган төгрөгийн 9 дэсийн 39 ширхэг үзмэрийг үнэ төлбөргүй хүлээн авч үзмэр, эд өлгийн зүйлсээр бүртгэж, сан хөмрөгийн баяжуулалт хийгдсэн бөгөөд тайлант онд 42,760.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой тус тус холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо болон өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 64,402.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 908,069.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3,780.0 мянган төгрөг, нийт зарлагыг 911,849.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 20,039.6 мянган төгрөгөөр бууруулж, 891,809.4 мянган төгрөгөөр баталсан нь төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бууруулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 888,029.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,780.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 778,892.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 3,311.0 мянган төгрөгийг бүрдүүлж, 778,892.8 мянган төгрөгийг зарцуулж, 3,311.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 778,892.8 мянган төгрөг буюу 87.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 79,976.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалын дэмжлэгийн зардлыг 1,400.2 мянган төгрөгөөр, музейн үзмэр худалдаж авах зардлыг 18,500.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71702-Соёл урлаг	891,809.4	778,892.8	112,916.6	87.3
1.1	80101- Үндсэн үйл ажиллагаа	826,922.8	746,946.4	79,976.4	90.3
1.2	80215-Эрдэм шинжилгээ, судалгаа	11,000.0	725.0	10,275.0	6.6
1.3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	26,057.6	24,657.4	1,400.2	94.6
1.4	81905-Музейн үзмэр худалдаж авах	18,500.0	0	18,500.0	0
1.5	81908-Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах зардал	9,329.0	6,564.0	2,765.0	70.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд 96,602.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

НТАГ-2026/410/НА-СТА-ТШЗ

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/33 дугаар захирамжаар агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт, шалгалт зохион байгуулахад 1,100.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зориулалтын дагуу гүйцэтгэлд зарцуулсан байна.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/470, А/471 дүгээр захирамжаар Монгол Улс, Унгар Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Унгар Улсын Будапешт хотод "Нүүдэлчдийн нийслэл хот" гэрэл зургийн үзэсгэлэнг 2025 оны 5 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Улаанбаатар хотын соёлын өдрүүд" арга хэмжээнд 41,658.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүжилтийг олон улсын үзэсгэлэнд дэлгэх 72 ширхэг гэрэл зургийг сонгох, худалдаж авах, засварлан томруулж угаалгах, хавтанд наах, зураг бүрд цаасан хүрээ, целлойдон тунгалаг нүүр хийлгэх, угсардаг жааз буюу хүрээ, гэрэл зургийг байрлуулах 73 ширхэг зориулалтын хөл мольберт худалдаж авах, баримтат кино хальс худалдаж авах, хадмал орчуулга хийлгэх, үзэсгэлэнд тавих гэрэл зургийг аюулгүй тээвэрлэх, зориулалтын хайрцаг, саванд баглах зэрэгт зарцуулсан байна.

Мөн нийслэлийн Засаг даргын 2025 оны А/833 дугаар захирамжаар "Нийслэлийн Иргэдийн баяр – Хүрээ цам Даншиг наадам 2025" шашин соёлын наадмаар Улаанбаатар хотын музейгээс "БОГДЫН ХҮРЭЭ БА УЛААНБААТАР" сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулахаар 53,844.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.

Монголын уламжлалт соёл, өв уламжлалыг сурталчлан таниулах, үр хойчдоо өвлүүлэх зорилготой Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр "Хүрээ цам-Даншиг наадам 2025" шашин соёлын наадмаар Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын Газартай хамтран Улаанбаатар хотын музейгээс 2025 оны 06 дугаар сарын 27- 29-ний өдрүүдэд Хүй долоон худагт дараах үзэсгэлэнг зохион байгуулан, олон нийтийн хүртээл болгон ажилласан байна. Үүнд:

- "Богдын хүрээ ба Улаанбаатар" түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн
- Нийслэл хотын түүхэн дурсгалт барилгууд болох Улаанбаатар хотын музей, Улсын их дэлгүүр, Гандантэгчилэн хийд, Виставка, Гадаад харилцааны яам, Гэрлэх ёслолын ордон зэрэг леги үзэсгэлэн
- "VIII Богд хааны гайхалтай ховор цуглуулгууд" сэдэвт уран зургийн үзэсгэлэн

Тус гэрэл зургийн үзэсгэлэнд Богдын хүрээ, Социалист Улаанбаатар, өнөөгийн Улаанбаатар гэсэн гурван цаг үеийг харуулсан 40 ширхэг гэрэл зураг дэлгэгдлээ. Богдын хүрээний үеийг харуулсан гэрэл зурагт XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн Их хүрээ, Нийслэл хүрээ, Хотын төв захын худалдаа үйлчилгээ, Богдын ордон, хотын ахуй соёлын байдлыг харуулсан гэрэл зургууд тавигдаж, даншиг наадам, Хүрээ цамтай холбоотой түүхэн гэрэл зургууд, социализмын үеийн гэрэл зургуудаас хотын ерөнхий дүр төрх, автобусны үйлчилгээ, хотын иргэдийн хувцаслалт зэргийг харуулж мөн өнөө цагийн Улаанбаатар хотын өөрчлөгдөж буй дүр төрх, шөнийн Улаанбаатар, онцлох гудамж, талбайг үзэж харуулсан гэрэл зургуудыг дэглэн үзүүлсэн. Нийслэл хүрээг виртуал орчинд танин мэдүүлэх, түүхэн дурсгалт барилгын орон зайг виртуал орчинд босгож, сэргээн харуулах програм хангамжийн ажил, тоног төхөөрөмжийн хамт хийгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар хотын музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар нийгмийн даатгалын тайлан, санхүүгийн тайлангийн уялдааг хангах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Туяа, аудитор Ц.Отгонжаргал, аудитор Н.Пүрэвсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, компанийн захирал Д.Товуудорж нар анхан шатны чанарын хяналтыг, НТАГ-ын Санхүүгийн аудитын албаны аудитын менежер Д.Отгонбаяр, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Г. Нандинжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэл дэх Төрийн газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 279,486.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,192.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахгүй, ажилтан, албан тушаалтнууд гадаад, дотоод албан томилолтоор ажиллаагүй зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлогын 930,474.92 мянган төгрөгийн 16 мэдээ, нийт мэдээлэлвэл зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон 98.0 хувийн биелэлттэй байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", гэсэн заалттай нийцсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын хувь оролцоо санхүүгийн тайланд 99,872.5 мянган төгрөгөөр, Улсын бүртгэлийн гэрчилгээнд 72,796.8 мянган төгрөгөөр туссан бөгөөд 27,075.7 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл; 5.1. "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлана. 5.1.4. үнэн зөв байх", санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагад улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд цалингийн дэлгэрэнгүй бүртгэл нийгмийн даатгалын баталгаажсан тайлангаас зөрүүтэй, шилэн дансны мэдээлэл хоцроосон, зэрэг нийт 23,146.5 мянган төгрөгийн 3 зөрчлийг илрүүлж, зөвлөмж өгсөн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 13,978.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмжийг хэрэгжүүлж 100 хувийн биелэлттэй ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	13,978.0	3	13,978.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>13,978.0</b>	<b>3</b>	<b>13,978.0</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газар төсвийн зарлагыг бууруулах зорилгоор төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээ тухайн байгууллагад хэрэгжээгүй байгааг дараагийн шатны аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,092.8 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 2,092.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл нийгмийн даатгалын болон татварын баталгаажсан тайлангаас зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:", 5.1.3-д. "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д. "үнэн зөв байх" заалт, санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн бүртгэлийг үнэн зөв тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусУад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл нийгмийн даатгалаас зөрүүтэй	1	2,092.8					1	2,092.8				
Дүн	1	2,092.8					1	2,092.8				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засгийн газрын хувь оролцоо дүрмийн санд 99,872.5 төгрөг, Улсын бүртгэлийн гэрчилгээнд- 72,796.8 мянган төгрөгөөр тусгасан бөгөөд 27,075.7 мянган төгрөгийн зөрүүтэй	1	27,075.7					1	27,075.7
Дүн	1	27,075.7					1	27,075.7